



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №40



2018 оны 11-р сарын 26-наас 12-р сарын 06

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1262** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 119(9.4%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1096(87%) хачигт халдвар, 25(2%) бэтэг, 2(0.1%) хумхаа, 10(0.8%) боом, 7(0.5%) тарваган тахал, ку чичрэг, татран, денгийн чичрэг өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол тус тус 1(0.07%) бүртгэгдээд байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1096** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.9%-иар бага байна.



Хачигт риккетсиозын 816 сэжигтэй тохиолдлын 199(24.4%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **119** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 20.6%-иар буурсан байна



ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:

11 дүгээр сарын 29-ний өдөр **Архангай** аймгийн **Хотонт** сумын Орхон багийн малчин “М”-ийн 2 үхэр мал, амьтны халдварт “Галзуу” өвчний шинж тэмдэг илэрсэн тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд 11.28-ны өдрийн 18-272 дугаар хариугаар тогтоогдсон байна.

Хариу арга хэмжээ:

- Тус сумын Засаг даргын 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/119 дүгээр захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон. 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар хяналтын 1 цэгт 5 хүн, 1 автомашинтай ажиллаж өвчилсөн 2 үхрийг устгаж, ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байна.
- Эрсдэлд хүн өртсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Эх сурвалж: ОБЕГ, Архангай ЗӨСТ

12 дугаар сарын 01-ны өдөр **Булган** аймаг, **Баяннуур** сумын малчин “З”-ийн 1 үхэр мал, амьтны халдварт “Галзуу” өвчний шинж тэмдэг илэрсэн тул дээж авч аймгийн МЭАЦЛ-д дээж авч шинжлүүлэхэд 12 дугаар сарын 01-ний өдрийн 210/222 дугаар хариугаар тогтоогдсон байна.

Хариу арга хэмжээ:


- Тус сумын Засаг даргын 12.01-ний өдрийн А/96 дугаар захирамжаар 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон. 12.01-ний өдрийн байдлаар 5 хүн, 1 автомашинтай ажиллаж, 1 үхрийг устгаж 300 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байна.
- Булган аймаг Баяннуур сумын ЭМТөв голомтод байсан гурван хүнд урьдчилан сэргийлэх зорилгоор галзуу өвчний эсрэг вакцинжуулалтанд хамруулж ажилласан байна.

Эх сурвалж: ОБЕГ, Булган ЭМТ

Олон улсад:

Африкийн гахайн халуурал өвчин: ОХУ


БНХАУ-ын Хөдөө аж ахуйн яамнаас 2018 оны 12-р сарын 03-ны өдөр тус улсын гурван бүс нутагт африкийн гахайн мялзан өвчний дэгдэлт бүртгэгдсэн тухай мэдээлсэн байна. Бээжин хотод фермийн 9835 гахай өртөмхий байснаас 85 гахай уг вирусээр өвчилж, 17 нь үхсэн байна. Түүнчлэн Шанси, Хэйлонжан мужуудад 156 гахай өвчилж, үхсэн тухай мэдээлжээ.



Эх сурвалж: <http://www.ecns.cn/news>

Эбола вирус халдвар: БНАКУ

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Kalunguta, Masereka, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвийн мэдээлснээр эбола вирус халдварын нийт 453 тохиолдол бүртгэгдэж үүнээс 268 тохиолдол нас барсан байна.




Эх сурвалж: ДЭМБ

Шар чичрэг: Өмнөд Судан улс

Өмнөд Суданы Эрүүл мэндийн яам 11-р сарын 29-ний өдөр Губуду муж, Сакуре хотод Шар чичрэг өвчний дэгдэлт гарсан тухай мэдээлсэн байна.

2018 оны 11-р сарын 23-д анхны сэжигтэй тохиолдлыг Сакуре хотоос мэдээлсэн ба уг хот нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго улстай хиллэдэг байна.

Тус улсын эрүүл мэндийн яамнаас тандалт судалгааг эхлүүлж, дээж цуглуулж үндэсний эрүүл мэндийн лабораторид Эбола, Марбург, Рифт хөндийн халууралт, Крым Конгийн цусархаг чичрэг зэрэг халдваруудын шинжилгээг хийж сөрөг дүнтэй тодорхойлогдсон ба шар чичрэг өвчний вирус эерэг дүнтэй тодорхойлогдсон байна.



Эх сурвалж: www.outbreaknewstoday.com

Өндөр хоруу чанартай шувууны томуугийн А(Н5N2) вирус халдвар: БНХАУ

2018 оны 12-р сарын 04-ны өдөр БНХАУ-ын мал эмнэлэг, Хөдөө аж ахуйн яамны мэдээлснээр тус улсын Юнлин мужид шувууны томуугийн А хүрээний Н5N2 вирус халдвараар нийт 3730 шувуу өртөмхий байснаас 146 шувуу өвчилж, 3584 шувууг устгасан байна.



Эх сурвалж: ДЭМБ

Энэ долоо хоногт **Архангай, Ховд, Төв, Багануур** аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн байна. Бусад салбар төвүүд ШУН-ийн eop@nczd.gov.mn, nczd.eop@gmail.com хаяг руу мэдээгээ ирүүлж байна уу?

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН НЭГЖ